



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2014 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2000 оны 3 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл (орон тооны бус)-ийн дүрэм”-ийн “Нэг” дэх хэсгийн 1.7 дахь заалт, Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу 2015 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эмэгтэйчүүдийн хувьд тэтгэвэр бодоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”)-ийг 22,5 жилээр тогтоосугай.

Хоёр. Энэ тогтоолоор баталсан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг холбогдох хуулийн дагуу тэтгэвэр бодоход баримтлахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Уртнасан)-т даалгасугай.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба (Саранчимэг)-нд үүрэг болгосугай.

ДАРГА



С.ЭРДЭНЭ